



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 10 сарын 09 өдөр

Дугаар А/25

Мандалговь

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус аймгийн Мандал хорооллын халаалтын зуухны ажлыг цаашид хариуцан ажиллах "Дундговь-Ус" ОНӨААТҮГ-т халаалтын зуухыг хүлээлгэн өгөх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Номингэрэл (Орон нутгийн өмчийн газрын хөрөнгийн бүртгэл, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: Б.Үүрийнтуяа (Орон нутгийн өмчийн газрын өмчийн ашиглалт, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн)

Э.Дүүрэнжаргал(ГХБХБГ-ын Барилга, хот байгуулалтын хэлтсийн Инженерийн дэд бүтцийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

М.Дашхүү (Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн барилга, хот байгуулалт, дэд бүтцийн бодлого хариуцсан мэргэжилтэн)

Б.Золжаргал (Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн эрчим хүчний хяналтын улсын байцаагч)

С.Ариунжаргал (Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл хариуцсан мэргэжилтэн)

О.Бархүү ("Дундговь-Ус" ОНӨААТҮГ-ын захирал)

Д.Нэргүй ("Ашид бьюлдинг" ХХК-ын захирал)

2. Ажил хүлээлцэх ажлыг 2024 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн дотор журмын дагуу зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Номингэрэл)-д даалгасугай.

ДАРГА



С.ХУЛАН

HS30YUQ0

HS

482412073